



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/253

Мөрөн сум

Төсөвт өртөгийн дээд хязгаар
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, 41 дүгээр зүйлийн 41.2.6, 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/51 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчноо хамгаалах, загас үржүүлэх, загасчлах жуулчлалыг хөгжүүлэх төсөл (Хөвсгөл)-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний зураг төсөл, тоног төхөөрөмжийн судалгаа, эрчим хүчний эх үүсвэрийг суурьлуулах болон барилга байгууламжийн зураглал загас үржүүлгийн техник эдийн засгийн үндэслэл боловруулах төсөвт өртөгийг 50,000,000 (тавин сая) төгрөгөөр баталсугай.

2. Төсөл арга хэмжээний зураг, төсвийг боловсруулах зөвлөх үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгч сонгож гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

3. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулагдах 50,000,000 (тавин сая) төгрөгийг Сангийн сайдын багцад батлагдсан VI.2.1.1 хуулийн дугаартай төсөл арга хэмжээний зардлын батлагдсан төсвөөс холбогдох хууль журамд нийцүүлэн гүйцэтгэлээр нь санхүүжүүлэх, төлөвлөгдсөн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тухай бүр тооцож, тайлагнаж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа), Санхүү төрийн сангийн хэлтэс (Г.Базар) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН